

ЗОХИОЛЧ Д.УРИАНХАЙН ТУУЛЬСЫН ЗОХИОЛЫН ТУУРВИЛ ЗҮЙН ОНЦЛОГ

С.Чулуунбат

Abstract

Writer D. Uriankhai is an artist who writes in many genres of literature and continues to create many volumes of works. Although his art can be classified into some categories of popular Western biographies, it is composed of the unique characteristics of the nomadic spirit, the wonderful depiction of natural phenomena and poetry, and the sense of freedom of the nomads who want to be independent. Due to this uniqueness, D. Uriankhai's writings have been translated into many languages and have become another unique representation and expression of the Mongolian spirit.

As with any writer or artist, it can be seen that his work and creativity have been closely related to the development of his worldview and thinking.

Түлхүүр үг: *Д.Урианхайн хүүрнэл зохиол, туурвил зүй, экзистенциализм, психоанализ, зүүд зөн, ёр бэлгэ*

Удиртгал

Зохиолч Д.Урианхай нь зохиол бүтээлээ уран зохиолын олон төрөл зүйлээр өргөн хүрээнд бичдэг өвөрмөц сэтгэлгээтэй зохиолч бөгөөд түүний зохиол бүтээл нь судлаач шүүмжлэгчдийн дунд маргаантай, сонирхол татсан сэдэв байдаг учраас туурвил зүйн онцлог, философи үзэл санааг тодруулахаар сэдвийг сонгосон юм.

Судалгааны ажлын зорилго нь зохиолч Д.Урианхайн туульсын зохиолын модернист бичвэрийн онцлог болон зохиолчийн философийн үзэл баримтлалыг авч үзэхэд оршино.

Уг судалгааны ажлыг гүйцэтгэхдээ индукц, дедукцийн аргад тулгуурласан бөгөөд нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, харьцуулах аргыг хэрэглэсэн юм. Мөн судалгааны ажлын хүрээнд зохиолчтой биечлэн уулзаж асууж судалж байсан болно.

Д.Урианхайн уран бүтээлийг тусгайлан судалсан бүтээл, дэлгэрэнгүй судалгааны материал одоогоор харьцангуй бага байна. Д.Урианхайн амьдрал төдийгүй түүний уран бүтээлийн талаарх судалгаа ч бас харьцангуй хожуу эхэлсэн шинэ тутам байдалтай байна.

Уран бүтээлийг нь гүнзгийрүүлэн судлахад дотоод гадаадын олон эрдэмтний онолын тайлбар, судалгаа, шүүмж зохих үүрэг гүйцэтгэсэн. Судалгаандаа Д.Урианхайн туульсын зохиол бүтээлээс экзистенциалист, психологи, психоанализ, зүүд зөн, ёр бэлгэ, контемпорари чиглэлд хамааруулж үзэж болох “Үхрийн эвэр шиг хоёр үдэш”, “Гудманд уулзсан бүсгүй”, “Толын салаа голдирлоо дагадаг”, “Алганаас ниссэн хараацай буюу Тэрэлжийн өдрүүд”, “Халуун зуны сүүдэр”, “Толь” зэрэг тууж, өгүүллэгийг сонгон авч задлан шинжлэв.

Зохиолч Д.Урианхайн туурвил зүйн онцлог. Зохиолч Д.Урианхайн хувь хүний ертөнцийг үзэх үзэл, зохиол бүтээлийнх нь туурвил зүй нь олон талт, нийлмэл бүтэцтэй байна. Д.Урианхай нь уран зохиолын олон төрөл зүйлээр бичдэг, олон боть зохиол бүтээл туурвисаар

байгаа уран бүтээлч юм. Түүний уран бүтээлийг өрнө дахинд дэлгэрсэн туурвил зүйн зарим ангилалд хамааруулж болох ч нүүдэлчдийн оюун санааны давтагдашгүй шинж, байгалийн үзэгдэл, яруу сайхны гайхалтай дүрслэл, юунд ч хашигдахыг тэвчдэггүй нүүдэлчдийн эрх чөлөөний мэдрэмж тодорхой хэмжээгээр илэрч байдаг. Энэ л өвөрмөц байдлаараа Д.Урианхайн зохиол бүтээлүүд олон хэлээр орчуулагдаж, монголчуудын оюун санааны бас нэгэн өвөрмөц төлөөлөл, илэрхийлэл болж ирсэн юм.

Аливаа зохиолч, уран бүтээлч хүний нэгэн адил уран бүтээл, туурвил нь түүний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний хөгжлийн зүй тогтолтой нягт холбоотой хөгжиж ирсэн нь харагддаг. Д.Урианхайн зохиол бүтээлийг тодорхой ангилалд оруулж болох бөгөөд уран бүтээлийн эхний жилүүдэд хамрагдах бүтээл нь тэр үеийн нийгмийн онцлог байдлаас шалтгаалсан социалист реализмын чиглэлтэй, уянга голчилсон байдаг.

“Миний ээж-миний хань” дурсамж эсээ (Залуучуудын үнэн №68.1964), “Хүн танаа” өгүүллэгийн түүвэр (1972), “Халуун зуны сүүдэр” (1985) тууж зэрэгт уянгын хандлагаас бодрол бясалгал, философийн эрэл хайгуулын шинжтэй болсоор байсан шилжилт ажиглагддаг. Гэвч түүний эхэн үеийн бүтээлийг бүхэлд нь уянгын хэв маягтай, нэгэн хэвийн зохиол байсан гэж үзэж болохгүй бөгөөд дотоод учир шалтгаан, гүн ухаарлын аястай, бясалгалын чөлөөт хэмнэлийн хэлбэрээр хүн, нийгмийн дотоод утга учрыг хөндөж байсан нь түүнийг бодрол ухаарлын хандлагатай зохиолч болж буйг харуулсан юм.

1990 онд Монгол оронд ардчилал, хүний эрх, эрх чөлөөг тунхагласнаар урлаг уран бүтээлийн салбар нээлттэй болж олон ургалч үзлийн үр дүнд өрнө дахины урлагийн олон урсгал чиглэл нэвтэрч, уран бүтээлчид хүчээ сорьж эхэлсэн ба энэ их өөрчлөлт хөдөлгөөний дунд зохиолч Д.Урианхайн зохиол бүтээл ч шинэлэг, өвөрмөц содон бичвэр, эрэл хайгуул бүхий болсоор байсан юм.

Зохиолчийн өөрийнх нь тодорхойлсончлон “оюутан ахуйд, орос хэлтэй болж шинжлэх ухааны ном товхимол хорхойсон уншсаар материалист сэтгэлгээтэй болж, сахиус онгонд сүсэглэдэг бөө мөргөлийн үзэл ойлголт минь залуу зандан оюун санааны минь дотоод “далайн” ёроол руу живж, оронд нь матери, шинжлэх ухаан, физик биеттэй биеэр харьцах механик харьцаа ул суурьтай байр эзэлснээр би материаллаг үзэлтэй болов. Марксизм-Ленинизмийн онол тайлбарлал миний идэр насны үеийг хамарна, 1970-аад оноос идеализм, буддизмд хэт автан материализмд итгэсэн мөртөө эргэлзэж эхлэв. Тэр үед дуализм, төв үзлийн ойлголт, хандлагад татагддаг, тэр ай савын бодрол эргэцүүлүүд бодол санааны минь орон зайд зэгсэн хавтгайг эзэлдэг байсан” (Д.Урианхай, 2000: 59) гэсэн нь түүний уран бүтээлд сэтгэлгээний бодрол нээлт, философийн ойлголт, ухагдахуун элбэг бөгөөд тийнхүү философийн олон ай савд хамаарах шашин хийгээд нийгмийн ухааны нийлбэр, нэгтгэл бүхий синкретик хандлага, ухаарал эсвэл эрэл хайлт бүхий бичвэрийн онцлогтой юм.

Тэр бээр Марксист философийн хүрээний нийгэмд боловсорч төлөвлөгөөний эдийн засагч мэргэжил эзэмшсэн хүний хувьд мөн энэ үзэл онол нь түүний зохиол бүтээлд тусгалаа олсон байдаг. Үүний нэгэн жишээг доорх хэсэгт ийнхүү дүрслэн бичжээ.

“- Идэх, уух юм ч яахав дээ, гол юм биш, хүн байгаа цагт хэзээд ая нь олдох юм! Харин идэх, уухаас илүү өдий төдий юмс өнөө чинь хүнд хэрэгтэй болчихжээ, ах аа!... гээд өвгөнийг учирлангуйгаар харж,

- Өнөө чинь өнгөрсөнтэй огт адилгүй! ном..., сонин..., зурагт..., орны хөшиг... гутлын тос..., шүдний оо..., за өөр юу ч байдаг юм, ухаан нь, үнэртэй ус, ор дэрний цагаан даавуу, гар утас... ер, хэрэглэхгүйгээр хүн амьдарч чадахгүй юмс тоо томшгүй нэмэгдчихсэн!!

Үндсэндээ урьд гэдсэнд ордог байсан юмны маань хагасыг толгойд, хагасыг нь сэтгэл санаанд гээд хүнийг хүн болгодог бүгдэд маань зарцуулах хэрэгцээ үүссэн байхгүй юу. Хэрэгцээ гэдэг хүний амьдралыг тэлдэг, их гүнзгийрдэг эд юм байна! гэвэл, өвгөн...

- Тэр хэрэгцээ чинь бүр хүнийг усалж орхилоо гэснээ, хуухай муу догжир! Хөгшин хөвөөгүй адын муу занд сургаж, нусаа арчихын нь зуургүй баллаж орхих нь гэм хө. Хүн улам л ахиад, улам л шунаад байхаас, “Больё оо, ханалаа” гэж хэлэх нь гонж! Улам л ... улам л! ... гээд зогссоноо, дахиад л,

- Тэр “хэрэгцээ” гэдэг чинь оёоргүй далай л гэсэн үг! Захад нь гарна гэж энэ галавт л лав байхгүй. Хүн нэг дэлхийг байтугай хэдэн дэлхийг эзэмшлээ ч гэсэн “тэр ч юм хэрэгтэй! Энэ ч юм хэрэгтэй” санагдаад санаа амарна гэж үгүй! Яагаад гэхээр, хүний цээжин дотор чинь ад үүрлэхсэн сэтгэлийг нь үргэлж өтөөгөөд ганц ч өдөр эрүүл, амар амгалан байлгахгүй! (Д.Урианхай, 2018: 91).

Энэ бол төлөвлөлтийн эдийн засгийн онол эзэмшсэн хүн хэрэглээний эдийн засгийн сул талыг гарган хэлж байна гэсэн үг юм. Энэ л зөрчилт санаа, өөрөөр хэлбэл капиталист, социалист өмчийн тухай философи, онол, нийгмийн тухай номлол сургаал бүх цаг үеийн туршид сэтгэгчид, философичдын хувьд мөнхийн сэдэв байсаар ирсэн гэхэд хилсдэхгүй.

Цааш нь тэрээр хэрэглээний онолыг шүүмжлэн өгүүлэхдээ:

“ - Хүн төрөлхтөн нисээд л байдаг, нисээд л байдаг! Өөрсдөө л бид, “урагшаа нисээд байна!” гэж тунхаглаад байгаа болохоос чухамдаа хаашаа нисэж байгаа нь огт тодорхойгүй! гэв.

- Миний бодоход, бүгд харин тодорхой байна шүү дээ, Наташа! Өнөөдөр хүн төрөлхтний амьдрал хэчнээн хурдтай урагш ухасхийнэ, төчнөөн хүчтэй арагш угзрагдаж, хэчнээн эрчтэй дээш хөөрнө, төчнөөн хүчтэй... өвчтэй хөндүүрээр дорогш унаж байна. Бидний “Хөгжил” гэж ойлгож байгаа юм харахад сайхан боловч бодоход маш эмгэнэлтэй байна шүү дээ. Гагцхүү бодоход ч бус, ер нь л, бүхий л үнэн нь бүхэлдээ маш эмгэнэлтэй байна шүү дээ. Гагцхүү бодоход ч бус, ер нь л, бүхий л үнэн нь бүхэлдээ маш эмгэнэлтэй! Юу гэвэл, хүн төрөлхтний энэ Нислэгийн хамаг эрчим... хамаг түлш шатахуун... хамаг тэжээгч шим гагцхүү газар дэлхийгээс л “сорогддог”. Юу л хэрэгтэй болно, бүгдийг л хөөрхий муу газар л ганцаараа өгнө. Бараг бүгдийг бараг ганцаараа! Энэ бол сүйрэл! Хамгийн бодитой гарцаагүй сүйрэл! ...” (Д.Урианхай, 2018: 92) гэх мэт хөгжлийн тухай философийн ялгаатай үзэл баримтлалаа илэрхийлсэн юм. Энд мөн мал аж ахуйт монгол хүний экологидоо ээлтэй байгалиас хамааралтай, уул усаа шүтэн дээдэлдэг сэтгэлгээний онцлогоос, мөн шашинлаг сэтгэлгээнээс шалтгаалсан үзэл хандлага байгаа юм. Гэвч энэ бүхний суурь сэтгэлгээ нь хаана байна гэдгийг ажиглан хариулт өгсөн нь сонирхолтой бөгөөд энэ нь:

“Монголчууд, хүний ухааныг цээжиндээ оршдог гэж үздэг юмаа. Цэцэн үг цээжнээс!... гэж ярьдаг. Харин европ хүмүүс бол... оросууд ч тэдний ижил, толгойдоо байдаг гэж үздэг. Тийм үү? Европынхон хүний ухаан бодлыг дан ганц уураг тархины үйл ажиллагааны “бүтээгдэхүүн” гэж ойлгодог. Европын шинжлэх ухааны нотолсон үнэн энэ юм. Харин сүүлийн үед, миний дуулснаар, зарим эрдэмтэд, судлаачид хүний бодол санааг дан уураг тархины үйл ажиллагааны бүтээгдэхүүн биш, хагас хугас хувьд нь гаднын үл мэдэгдэх, үл танигдах орчны эрчим, магадгүй, бүүр хий юмсын нөлөө ч оролцож байна гэж тогтоож байгаа дуулдсан. Үүнд би маш үнэмшиж байна. Яагаад гэвэл, хүн маань өөрөө хүнээс аль дивангарын түрүүнд үүссэн орчлон-Эхийн үр, орчлонгийн ил далд бүтээгдэхүүн шүү дээ! Ингэхлээр, уураг тархи ч, уураг тархины үйл ажиллагаа ч анхнаасаа ямар хөтөлбөртэй, ямар задаргаа, ямар үргэлжлэлтэй тогтолцооны “бүтээл” юм билээ, бүү мэд! Ямар ч гэсэн, хүний ухаан цээжиндээ буюу сэтгэл дотроо байдаг гэж үздэг монголчуудын ойлголтод би жаахан сүсэг бишрэлийн чиглэлтэй ханддаг юм. Монголчуудынхаар, уураг тархины ухаан бус “Цээжний ухаан” л хүний гол ухаан, жинхэнэ хүнлэг, халуун, хамгийн элгэмсэг дотоод ухаан юм.

- Хүн төрөлхтний ухаан ч хүний учрыг олох гэж их л эрэлд хатаж байна л даа, чааваас! Харамсалтай нь, хүн төрөлхтөн даанч ухаантан мэргэдийнхээ үгийг дагахгүй... юм харла гэж. Уг нь ухаан л хүний амьдралыг төгсжүүлэхээр зогсохгүй, эцсийн бүлэгт, өнөө гайхал мөнгийг

нь ч огт хэрэггүй болгох арга замд хөтлөх ганц юм нь байж байгаа шүү дээ! (Д.Урианхай, 2018: 95) гэсэн нь философийн хувьд яах аргагүй гүн бодомж мөн. Өөрөөр хэлбэл хүн зөвхөн тархиараа боддог, шийдвэр гаргадаг төдий биш, тархи оюунаар сэтгэн бодсон зүйлээ зүрх сэтгэлийн шүүлтүүрээр оруулж байж гаргадаг гэсэн санаа билээ. Зохиолч үүнийгээ цааш гүнзгийрүүлж орчлон-Эхийн бүтээгдэхүүнтэй холбон үзэж байгаа нь сонирхолтой юм. Энэ нь зохиолчийн гүн ухааны бодрол буюу түүний үзэл бодлын тусгал болж байна. Өөрөөр хэлбэл цээжний ухаан гэдэг нь зүрх сэтгэлийг хэлж байх шиг. Хүн тархиараа бодож шийдвэр гаргадаг ч энэ бүхний үндсийн үндэс нь цээжний ухаан буюу зүрх сэтгэлээс гаралтай. Энэ нь зарим талаар ЗХУ-д сурч амьдарч байх үедээ буюу Оросын ортодокс шашны соёл, ертөнцийг үзэх үзэлтэй танилцан, зарим талаар нүд нээгдэн, хараа хандлага өргөжин тэлсэн, нөгөө талаар өөрийн үндсэн үзэл төлөвшилтэйгөө харьцуулан нэгтгэсэн үзэл бодол бүхий болж байсан гэмээр харагдаж байгаа юм.

Зохиолч дээрх санаагаа дэлгэрүүлэн: “Ертөнцийн мөхөл, хүн төрөлхтний түүхийн сүйрлийг мэдэрч байгаа мэдрэхүй ч эмзэглэл ч хоёулаа монголчууд бидний цээжин дотор ялгаагүй л нитгэрсээр байна л даа, Наташа!

Гагцхүү яаж аврах вэ? гэдэг нь хариултгүй, монголчууд бидэнд ч, оросууд та нарт ч тодорхойгүй...ямар ч арга зам харагдахгүй, үнэнийг хэлэхэд, хүн төрөлхтний зам, түүх, хөгжил буруу байгааг хүн төрөлхтөн өөрөөсөө нууж, буруугаа өөртөө хүлээн зөвшөөрөхийг... өөр зам руу эргэхийг хүсэхгүй, харин ч ихэнх хэсэг нь хамаг хүч, хөрөнгөөрөө эсэргүүцэн тэмцэж байна. Өнөөгийн энэ ямар ч утгагүй ахуй, ад албингийн мунхруулгад дөрлөгдсөн энэ их үйлдвэржилт, техникжилт, хотжилт гэх мэт “сүйрлийн хөгжил”-ийг хүн төрөлхтний далд ухамсар, дотоод гэгээний гялбаа битүүдээ “тэмтэрч”, түүнийг эсэргүүцэх хүсэл ч юм уу ямар нэгтээ маш нягтаар хуралдаж байна... одоо хүн төрөлхтний гол зорилго бол өөрийгөө өөрийн мөн чанар дотор байгаа гэмээс... өөрөө өөрийгөө егүүтгэх аюулаас аврахын зэрэгцээ, дээр нь, хамгийн гол нь, тэнгэрийн гэсгээлээс аврагдах зорилго гэж би боддог... (Д.Урианхай, 2018: 96) гэсэн үүнийг “номлол өгүүллэг” гэсэн нь ч тохиолдлын санаа биш юм.

Энэ хүрээнд түүний хийсэн нэг сонирхолтой бөгөөд зоригтой оролдлого бол “Бодь сэтгэл, эв хамт ёс-ганцаарчилсан хөдөлгөөн”-өөс нийгмийнхээ бүх даваргаажилт, салбарын ажилтан, мэргэжилтэн, сэхээтнүүдэд илгээх философи захидал-учирлал” хэмээх урт нэртэй философийн нийтлэл болно. Өөрийнх нь тодорхойлсноор энэ нь “Үндэсний ахуйн биеэ даасан хөгжлийн “Монгол гүн ухааны систем” боловсруулах оролдлого” юм гээд тийнхүү “Алив үндэстний нийгмийн хоцрогдлын гол шалтгаан нь тухайн үндэстэн оюун санаа, сэтгэлгээний хувьд биеэ дааж чадаагүй, ахуй оршихуйнхаа зорилго, утга агуулгыг тодорхойлох үндэсний философи сэтгэлгээний “тусгаар тогтнол”-оо бодитой олоогүй, ертөнц, нийгэм, хүний амьдралын хөгжил, үйл явц, зүй тогтлыг өөрийнхөөрөө үзэх, өөрөө бие даан танин мэдэх, тайлбарлах “Үндэсний гүн ухаан”-ы тогтолцоог боловсруулаагүй, бусдын оюун санаа, сэтгэлгээний үзэл баримтлалын заавраар “дөрлүүлэн” амьдарч байдагт оршдог юм байна... Тэр хэцүү, гашуун асуулт, -“Миний эх орон, миний ард түмэн түүхэн туршаа (XIII зууныг эс оролцуулбал) эдийн засгийн хөгжил, ахуй амьдралынхаа түвшнээр яагаад ямагт бусдаас тээр доор хаягданги, бусдаас ямагт хараат, улс төрийн харилцаа хэдэн зуунаар дандаа бусдын эрх мэдэлд атгаастай, ард түмэн минь яагаад оршихуйнхаа бүх хугацаанд дандаа тартаг, зүдүүгийн “хараал идсэн” гачигдал, хясаанд нэрвэгдэж амьдарсаар ирснийг, өнөө ч хэвээр амьдарсаар буйн гол шалтгаан чухам юунд байна вэ? Яагаад бид энэ бодит үнэний боол хэвээр (XXI зууны эхний мөчлөг ороод!) амьдралаа үргэлжлүүлэхэд хүрч байна вэ? гэдэг асуулт!” (<https://sonin.mn/news/culture/126762>, 2021.12.13) гэжээ.

“Үхрийн эвэр шиг хоёр үдэш” (1974) ёж өгүүллэгт Шүрээ, Сараа гэх найз хоёр эмэгтэйн дүр гарах бөгөөд социалист монголын хот газрын эмэгтэйчүүдийн тодорхой дүр юм. Шүрээ найз Саранчимэгийн дээ орж ярьж байгаад хэдхэн цагийн (энэ хэсэг нь тэдний амьдралын хэмнэл буюу бүхий л амьд насны хугацаа нь болж байгаа) дараа гарах үед түүнтэй таарсан өсвөр

насны хоёр охин бол түүнийг анх ороход нь таарсан хоёр жаахан охин юм. Тэд бол монголын ирээдүй буюу шинэ цагийн төлөөлөл болно. Үе хоорондын ялгаа, үе цагийн зөрүү гэлтэй. Мөн тэр хоёр охин тэдний өнгөрсөнд үлдсэн дурсамж, тэдний амьдрал ч байх боломжтой. Хоёр охины харилцан яриа, хоёр хүүхний яриаг мөн харгацуулсан энэ өгүүллэгээ 1974 онд бичсэн гэвэл энэ нь зохиолчийн модерн, экзистенциалист туршилт тэр үеэс эхтэй гэж үзэж болохоор байгаа юм.

“Гудманд уулзсан бүсгүй” өгүүллэгт “Сэтгэлд гунигтай, цээжин дотор намрын зэгсний исгэрээ шуранхайлах мэт жихүүс хургаж, өдөр радиогоор сонссон “Аргагүй амраг”-ийн аялгуу, мөр бадгууд ой тойнд нь эргэлдэн яагаад ч юм, өөрөө л намар орой цас мөс зууралцсан голын усанд хөвж яваа өнөө муусайн загас жараахайс ч юм шиг, тэгээд дээгүүр доогуураа хөвөх зайранд бяц няц дайрагдчих гээд аль нэг завсар зайгаар нь ам ангалзан зугатаж яваа ч юм шиг санагдаж баргар царайгаа улам барайлгав. “Хүний жаргалын түлхүүр хүнд өөрт нь, өөрийн атганд байдаг, тэр түлхүүр бол хүний шударгуу ариун хөдөлмөр!” гэж өөрөө дотроо боддог, үнэхээр ч тэгж итгэдэг, мөн үр хүүхдэдээ ч үнэн голоосоо тэгж сургаж ятгадаг, аль дивангараас өөрөө, өөрөө арав гаруйхан настайгаасаа эхлээд аз жаргал амтлах гэж өчүүхэн биеэ мод, хад шиг хайр гамгүй эдлэн мөнөө жаргалын түлхүүр-ажил хөдөлмөрт цаг наргүй зарсан хэр нь өнөөг хүртэл тэр “түлхүүр” атганд нь орж ирсэн нь үгүй санагдаж, яагаад юм амьдралдаа анх удаа хувь заяандаа гутрах, тэнгэр бурханд гомдох сэтгэл цээжин гүнээр нь барс хийгээд явчихав. “Ажил, ажил!” гэж арьс махаа салмартал зүтгэлээ. Хий гэсэн юуг ч хэр чинээнийхээ туйлаар, хүнээс ер доргүй хийж явлаа! “Хэнхэг” гэж л хэлүүлэхээр чармайснаас биш, “хойрго” гэж хэнбугайд ч чичлүүлэхээргүй хичээж мэрийж ирсэн байх! Хүнд, наанаа хатуу гөжүү үгийг хэлэвч цаанаа хар гэм санасангүй, үнэнч шударгууг л үргэлж мөрдөж, сайн муу, сайхан муухайг тэгш л үүрсээр амьдралаа тууллаа даг! Тэглээ гээд хаа байна, үүний хариу! Хаа байна, өнөө түлхүүр?! Эсвэл, хүний хувь тавилангийн эрх хүнд өөрт нь, гарт нь байдаг нь худлаа, хахь өөр газар, хүнээс өөрөөс нь үл хамаарах хол, хүнийг үл ойшоогч, үл тоогч, хүйтэн авилган эзгнэгчийн гарт, яг энэ..., цонхоор юу харах гэсэн юм бүү мэд, юу ч үл үзэгдэх хоосон хөх тэнгэрээс юу олж харна ч гэж бодсон юм бүү мэд, гунихрангүй, усан цийлгэр нүдээр цонх руу гөлрөн ширтэж, “Хэн рүү утасдъя даа байз? Хэнд хэлвэл, хэдэн төгрөг надад зээлдүүлж, орой аяга хоолны махтай харих мөнгө залгуулдаг бол?” гэж санаашран утас руугаа гар сарвайснаа буцаагаад татлаа... (Д.Урианхай, 2018: 136).

Энэ нь ёс суртахууны мөн чанарыг хөндөж байгаа философийн асуудал бөгөөд шударга байдлыг сонгосон хэн хүнд амьдралд нь хэдэнтээ тохиолддог эргэлзээ, тээнэгэлзэл, амьдралын сорил шалгуур гэлтэй. Энэ нь хэдий философийн ухагдахуун мэт боловч үндэстэн угсаатны үнэт зүйл, соёл сэтгэлгээний тун хол, гүн далдын утгатай зүйл юм. Гагцхүү үүнийг бидний улс хэрхэн сэрж, авах орхихоос үндэстний цаашдын замнал хамаарах мэт. Энэ нь мөн эрт үеэс философийн чухал асуулт байсаар ирсэн бөгөөд Аристотелийн “Евдемийн ёс зүй” - н дөрөвдүгээр дэвтэрт гардаг шударга ёсны ойлголттой тохирч байна. Тэнд өгүүлдгээр “Хүмүүсийг шударгаар авирлах чадвартай болгож байгаа чанарыг, өөрөөр хэлбэл, үр дүн нь хүмүүс шударгаар үйлддэг юмуу шударгаар үйлдэхийг хичээдэг болгодог тэрхүү чанарыг шударга ёс хэмээн нэрлэж заншжээ..., “шударга хүн” гэдэг бол хуулийг сахидаг, тэгш ёсыг баримталдаг тэр хүн юм..., шударга бус хүн хомхой шунахай байдаг болохоор ямар нэгэн сайн сайхныг их сонирхдог, тэгэхдээ бүхий л сайн сайхныг бус, харин аз, азгүйдэл хоёрт холбогдох сайн сайхныг сонирхдог...ингээд үзэхээр шударга ёс гэдэг бол, хэдүйгээр туйлын биш ч гэсэн, төгөлдөр агаад бүрэн бүтэн сайн үйл юм...” (Аристотель, 2008: 92) гэдэг энэ тодорхойлолттой зохиолч Д.Урианхайн бодрол тохирч байгаа юм.

Өөр нэгэн өгүүллэг “Толын салаа голдрилоо дагадаг” өгүүллэгт: “Өвчтөн амаа эвгүй ангайн дэрнээсээ өндийснөө чийдэн өөд гөлрөөд харц нь тогтчихов. Хэдэн хором чийдэнгээс огт харц салгалгүй, нүдээ огт цавчилгүй, адарт гэрэлтэх тэрхүү бөөрөнхий цагаан юмыг анх харж жигтэй гайхах мэт ширтээд, ямар нэг юмны учрыг олох гэж туйлаас мэрийх мэт ихэд

шаргуу ажиглалаа.

Үнэхээр, өвчтөн адарт зэрэглээтэх гэрэл, чийдэнгийн бүрчигээс цацрах шаргал туяаг ширтэлхийлэхдээ, “Энэ чинь юун улс вэ?” гэж дотроо ихэд гайхжээ. Юу гэвэл, дан цагаан нөмрөгтэй, дан цагаан морьтой улс Чачиртын давааны энгэрээр хөндлөн гулд давхилдан, урт сэлмэн эвэртэй том ягаан бух цасанд хучаастай өндөр, хүнхэр эргийн мөргөцгийг ууртай шөргөөн, эврээрээ хунгар сэжлэн сэгсэрч толгой дүйртэл урамдан мөөрөх агаад урд хоёр хөлийнхөө туураар цас ээлжлэн малтаж арагш чөлөө зайгүй цацах нь өвчтөнийг-амьсгаа авах аргагүй булан, ар нуруу руу нь хүйт оргиулан унах шиг санагджээ. Царай зүс нь харагдахгүй нэг хий, эчнээ дуу “Уналаа! Уналаа! Уналаа!...” гэж тасралтгүй давтан хашгирч, тэгэхээр нь, Хаана, юу унаж байгаа юм бол? Хэн, юу унагаад байгаа юм бол гэж нүдээ бүлтэртэл ажигч тодорхой юм юу ч харагдахгүй, өнөө л олон олон цагаан морьтой, цагаан цагаан нөмрөгтэй улс учир зүггүй хашгиралдан хуйларч Чачиртын давааны бэл дүүрэн давхилдсаар байх аж.

Өнөө ягаан зүсний үхэр нэг харахад улаан болж, нөгөө харахад шар болж, сүүлдээ цав цагаан болоод мөөрөх ч үгүй, эрэг гуу шөргөөх ч үгүй, цас хунгар сэжлэх ч үгүй, эцсэн мэт огт хөдлөхгүй, осгон бээрч буй мэт дагжин зогсоноо цас руу живээд үүл сарних мэт алга болчхов. Тэгэхээр нь өвчтөн зовхио алгуурхан буулгаж нүдээ анив. Өвчтөний уруул үл мэдэг хөдлөн үг хэлэх шиг болоход Янжмаа доромш бөхийн чих тосвол, -Ээждээ цагаан хайнаг унуул! гэж хэлэх дуулдлаа.

Юу, аав аа? Юун хайнаг? гэхэд аав нь юу ч ойлгосонгүй, юу ч дуугарсангүй, зовхио ягуухан сөхөн, дахиад л өрөөний адар ширтэн гөлөрснөө төдөлгүй нүдний нь гал бөхөн харц нь царцчихлаа. Янжмаа яах ч учраа олохгүй хий л, -Ээж ээ! гэж чарлаад хажуудаа зогсоо эмчийн гараас тас базан авч нүүрээ наалаа... (Д.Урианхай, 2018: 159).

Зүүдэнд л харж болох ийм үзэгдэл нь сэтгэхүйн хүрээний хачирхалтай дүрслэл бөгөөд энэ нь хүний амьдралд хэдэнтээ тохиож болох ч ихэнх хүнд клиник үхлийн мөчид, эсвэл амьсгал хураах үед болдог, эсвэл заарингийн зөн совинд буудаг тэр нууцлаг дүрслэлтэй адил юм. Энэ туршлага магадгүй хүн бүхэнд тохиолддог байж болох ч үүнийг ийнхүү уран зохиолын хэлээр туурвин буулгах нь зохиолчийн авьяас билгээс гадна сэтгэхүй, мэдрэмжийн хувьд ямар нэгэн өвөрмөц туршлагыг илтгэнэ. Зохиолч Д.Урианхайн зохиол бүтээлээс ийм сэтгэлзүйн дүрслэл, психоанализ маягийн дүрслэл, үзэгдлийг олонтаа олж үзэж болно. “Толын салаа голдрилоо дагадаг” өгүүллэгт буй өвчтөний сэтгэл зүй бол;

“Цонхны цаанах нэг хачин хүн, цонхны наанах бас нэг хачин хүн” (2014) өгүүллэгт гардаг өвчтөнд үзэгддэгтэй адил үзэгдэл юм.

“Үхэл гэж, ингэхэд, чухам юу юм? Үхэж үзсэн, үхээд, газарт булагдаад жил болсон, арван жил... зуун жил болсон хэн булшнаасаа босож ирээд хэнд, ямар хүнд, хэзээ “Үхэл гэдэг ийм юм байна! Хүн үхсэнийхээ дараа ингэдэг, ингэдэг юм байна!” гэж хэлсэн юм?! Үхэл юугаараа муухай, юугаараа амьдралаас дор, юугаараа хүнийг айлгадаг, сэтгэл бодлыг нь гутраан үзэн ядуулдаг юм? Юуг нь бодитой, магадтай мэддэгтээ хүн үхлээс жийрхдэг юм?! Магадгүй, бид үхлээс бус амьдралаас айдаг, амьддаа аймшигтай аймшигтай нүгэл, хилэнц үйлдэж явсныхаа асар их тоотой нийлбэрээс амьдралынхаа эцэст нэгэн өдөр айж сүрдэхдээ эцсийнхээ амьсгааг, бие махбодийнхоо “бодисын солилцоо”-ны төгсгөлийг, нүгэл ч бай, буян ч бай, алив үйл үйлдэж чадах эцсийнхээ боломжийн “боломжгүй”-г “Үхэл” гэж нэрлэж зуршсан, тэгж нэрлэснээ яг зөв, яг онож тодорхойлсон гэж үнэн голоосоо үнэмшдэг, бидний оюун ухаан, ажил хөдөлмөрийн туршлагын үр дүн эцэстээ бидэнд “Үнэн гэж энэ!” гэж нотлон итгүүлдэг, шинжлэх ухаанч тийнхүү худлаа, буруу нэр мунхгаар оноочихсоны харгай байж магадгүй биш үү? гэж бодон өөрөөсөө асуудгаа асуулаа” (Д.Урианхай, 2018: 394) гэдэг. Энэ бол мөн л хүн төрөлхтний мөнхийн асуулт, хариултыг нь хайж ирсэн сэдэв юм. Шинжлэх ухаан үүнийг судалсаар байгаа бөгөөд шашин мөн үүнд өөрийн гэсэн хариулт өгсөөр ирсэн байдаг. Олон олон өөдрөг уран бүтээлчид, урлагийнхан мөн өөрсдийн хариулт болох оюуны эрэл

хайгуулынхаа үр дүнгээр хүн төрөлхтний оюуныг баясган цэнгүүлж, бас бодуулж, нэгэн зэрэг мөн эргэлзүүлэн, дургүйцлийг нь төрүүлж ирсэн тэр л зүй тогтлын ёсоор зохиолч Урианхай ч мөн өөрийн гэсэн үзэл бодол, үг санаагаа уран бүтээлээрээ дамжуулан ийнхүү тунхагласаар байгаа билээ. Харин;

“Тэрэлжийн өдрүүд...Намар оройн хараацай” (1979) өгүүллэгт: “Бурханы үнэн шиг үнэн байх юм бол бүүр бүгдээс л илүү сайхан! Жинхэнэ... бараг худал юм шиг санагдаад хүн үнэмшиж чадахааргүй үнэн бол хамгийн гоё. Харин урлаг шал өөр! Бодоод байхад урлаг бол худлаа гэмээр үнэн юм шиг байгаа юм. Амьдралд хаа ч тохиолдохгүй гоо сайхан юмны нууц чанар урлагаар дамжиж л илэрдэг байж ч магадгүй!

Товтой хариу олж эс чадавч энэ асуултндаа бага хүүхэд мөхөөлдсөнд дурлах мэт дурлан, хариулж чадахгүй “муу дүн” авах бүрийдээ харин ч сайхан тайвшрах аж. Тэгээд, амьдралаа дуусгаж байгаадаа, хэзээ мөдгүй, тун удахгүй үхэлтэй нүүр тулан тэврэлдэх гэж байгаадаа санаа амрах ч шиг, баярлах ч шиг, хамаг өвчин нь эдгэрээд бие нь эв эрүүл, хүч тамираар дүүрээд ирэх ч шиг болоод орноосоо сэмхэн, хурдан босоод суниамаар санагдлаа.

Амьдралын нь хамгийн жаргалтай, хариуцлагатай мөч одоо л ирж байх шиг сонин сэрэл, цоо шинэ мэдрэмжийн урь биеэр нь халуунаар урсаад, өвчтөн өөрийн бат бодлоо, Өвчтөний санаа бодол, яагаад ч юм, энэ шөнө гайхмаар бодогдож байгаагүй сонин сонин бодлууд хойно хойноосоо зэрэгцэн чихэлдэж, энэ шөнийн нам гүмийг бусдууд шигээ унтаж, хухирч, ёолж, яраглаж өнгөрөөснөөс толгойд нь өөрөө аяндаа төрөөд байгаа бодлуудтайгаа нөхөрлөж, баярлаж, хуурмаг ч бай, үнэн ч бай, хэсэг хугацааны тайвшрал олж шөнийн харанхуйн зовлонг гэтлэн өнгөрөөж буй нь хүсүүштэй сайхан амар жаргалыг авчирч байлаа...

Үхэл, - амьдралын хамгийн сонин, хамгийн баялаг, нууцлаг Ирээдүй байгаа байх! Магадгүй, цоо шинэ, үл төгсөх, үл төсөөлөгдөх амьдрал ч байж мэднэ. Амьдрал бидний мэдэх төлөвдөө эхнээс эцэс рүү, төгсгөл рүү урссан цаг хугацаа бол үхэл төгсгөлөөс эхлэл рүү... эхлэлийн төгсгөлгүй давтамж руу очиж буй цаг хугацааны ирэлт байхыг хэн мэдэх юм? Тэр, -амьдралын харагдахгүй залгаас, тусгал, нэгэн насны төгсгөвөрт амьдралыг орлон нөхөгч өөр амьдрал, гагцхүү, үл тайлагдах, үл нээгдэх гоо сайхан чанартай, эрч идэвхитэй, бас, хөгжилтэй баярт мөчүүдтэй, үл төгсөх хөдөлгөөнтэй, түүгээрээ ч даван туулахад аймшигтай хэцүү хүчирхэг сорил, ялалт байнга амдаж байдаг дээд эрэмбэ түвшний амьдрал ч байж болно шүү дээ!” (Д.Урианхай, 2018: 396) гэх буюу мөнөөх л цагаан морьд ахин дүрслэгдэх нь; “Сүүдэрт хучигдсан, зах хязгааргүй алслан нүүгэлтэх тал руу хаанаас юм, хаа нэгтгээгээс олон цагаан морьд давхилдан үймж аснаа хаашаа юм, хаа нэгтээ хүү алга болоод ганц цагаан морьтон, толгой нүцгэн, тод улаан навстай лам хүн өөр рүү нь гар даллан таваргалаа... Цагаан морьтон өвчтөний эгц урдаас, толгой дээгүүр нь харайх шиг дүүлтэл, морьтой хүн нь морьтой хүн бус, ганц цагаан тогоруу болж өвчтөний дээгүүр, их ойрхонуур эргэлдсэнээ өөртэй нь цуг хаа нэг зүг зүйргүй их хурдтай нисэн, жигтэйхэн хөнгөхөнөөр хөөрөн хөвөв...” (Д.Урианхай, 2018: 398).

Зүүд зөн мэт боловч бас үзэгдэл гэж хэлдэг тэр зүйл ч юм шиг, эс бөгөөс хүний ухамсарт, мөн үл ухамсарлахуйд болдог оюун сэтгэхүйн үйл явц гэлтэй. Үүнийг оюун санааны туршлага сайтай хувь бодгаль ойлгож мэдрэх, эсвэл үхлийн өмнөх шат, магадгүй клиник үхлийн үед болдог байж болох юм. Зохиолчийн нэг сонин санаа энд гарч байгаа нь үнэмлэхүй үнэнийг Бурхан буюу шашны номлолын талаас сонгож байгаад оршино. Үүнийгээ “Харин урлаг шал өөр! Бодоод байхад урлаг бол худлаа гэмээр үнэн юм шиг байгаа юм. Амьдралд хаа ч тохиолдохгүй гоо сайхан юмны нууц чанар урлагаар дамжиж л илэрдэг байж ч магадгүй!” (Д.Урианхай, 2018: 398) хэмээн эргэцүүлсэн байх бөгөөд үүгээрээ зохиолч Д.Урианхай нь шашны философийг талархан баримтлагч, бясалгалын номлолыг дэмжигч гэж тодотгогдох боломжтой юм. Өгүүллэгт цааш нь өвчтөн нэгэнт амьсгал хурааж, түүний хувьд бүх юм төгсөж, дуусаж байх мэт боловч бас нэгэн зэрэг бүх юм эхэлж, цоо шинэ амьдралын хаалга нээгдэж байх мэт энэ төгсгөл нь доктор Мүүдийн “Үхлийн дараах амьдрал” номын үзэл санааг дэмжин өрнүүлж байх мэт.

“Өвчтөний амьсгаа замхран замхран залирсаар нам жим арилж, царай нь амарлингуйяа цайвартан хөшөөд, хүссэнээ гүйцээсэн хүн аз жаргалдаа бахархан өөрийн мэдэлгүй баяртайгаар инээд алдах шиг хачин их жаргалтай инээмсэглэл хөшиж цонхийсон царайндаа үлдээгээд өглөө нар мандах шиг анир чимээгүй эсэнэлээ... аль нь ч ялгаагүй, орчлонгийн юм бүхэн, орчлонд юу юу буй тэр бүхэн мөнх бус ч, мөнх бус нь худал, мөнх нь үнэн! гэж нотлон өгүүлэхийг хүссэн мэт байдаг байдгаараа оршин үргэлжилж нүд булаах ажээ (Д.Урианхай, 2018: 398).

“Үхэл юугаараа муухай, юугаараа амьдралаас дор, юугаараа хүнийг айлгадаг, сэтгэл бодлыг нь гутраан үзэн ядуулдаг юм? Юуг нь бодитой, магадтай мэддэгтээ хүн үхлээс жийрхдэг юм?! Магадгүй, бид үхлээс бус амьдралаас айдаг, амьддаа аймшигтай аймшигтай нүгэл, хилэнц үйлдэж явсныхаа асар их тоотой нийлбэрээс амьдралынхаа эцэст нэгэн өдөр айж сүрдэхдээ эцсийнхээ амьсгааг, бие махбодынхоо “бодисын солилцоо”-ны төгсгөлийг, нүгэл ч бай, буян ч бай, алив үйл үйлдэж чадах эцсийнхээ боломжийн “боломжгүй”-г “Үхэл” гэж нэрлэж зуршсан, тэгж нэрлэснээ яг зөв, яг онож тодорхойлсон гэж үнэн голоосоо үнэмшдэг” гэсэн энэ бодол санаа бол чухам библи судрын үзэл санаанаас ургуулсан гэлтэй. Библид үхэл бол гэмийн хөлс гэж үздэг тэр үнэнийг энд монгол сэтгэхүйн чанадаас хүүрнэж байна. Тийнхүү амьд ахуйдаа нүгэл гэмээ уучлуулсан хүн үхэхдээ сэтгэл амар, тайван жаргалтай оддог гэдэг. Үүгээрээ л зохиолч Урианхай өрнө дахинд судлаач шүүмжлэгчдийн анхаарлыг татах болсон гэлтэй. Үүнд мөн түүний туурвил зүйн өвөрмөц арга барил, модернизмын олон төрлийн бичвэрийн арга барилыг ашиглан бичиж байгаа нь ч нөлөөлсөн тал байдаг юм.

“Халуун зуны сүүдэр” туужид “...дүрийн тогтолцоонд ашигласан бэлгэдэл, зөн совингийн өвөрмөц хэлбэр, шийдлүүд нь аргын хувьд, уран сайхны бүтцийн хувьд тухайн үедээ шинэлэг болж чадсан байна... Хөдөөгийн хүмүүсийн сэтгэл санааны байдал, өсөлт хөгжилт, амьдрал дахь шүүмжлэлт зүйлийг сонирхолтой хурцаар тавьж, түүнийгээ гүн ухааны аястай, уран дүрслэлийн сонирхолтой /зөн билиг/ аргыг чадамгай ашигласан сонирхолтой зохиомжтой бичсэнээрээ манай өнөөгийн тууж бичлэгт нэгэн өвөрмөц шинэ бүтээл болсон” (Ред. С.Байгалсайхан, 2017: 424) гэх мэтээр уран зохиолын судлаач шүүмжлэгчдийн дүгнэлтэд олонтоо давтагдаж байдаг нэг тодорхойлолт бол зөн билиг, сэтгэлзүйн, гүн ухаан гэх нэр томьёо бөгөөд эдгээр нь зохиолч Д.Урианхайн онцлог талыг тодорхой хэмжээгээр илэрхийлж байна.

“Толь” өгүүллэгт үхэл мөнх бус хийгээд хүний мөн чанар, жинхэнэ оршихуй гэж юу болох, сүнс амь-үхлийн дараах амьдрал гээд үл ухамсарлахуйн (subconscious mind далд ухамсар гэж хөрвүүлэх нь тохиромжгүй, энэ ойлголт бол психоанализтай хамаарахгүй чанад зүйл юм) тухай юм. Өгүүллэг ийнхүү гол баатар нь “хий юм”-тай таарснаар эхлэх бөгөөд энэ мөчөөс эхлэн гол баатар нь Болд биш “хий юм” болж өөрчлөгдөнө. Энэ бол чухамдаа хэн нь жинхэнэ оршихуй юм бэ гэдгийг асууж байгаа зохиогчийн дэвшүүлж буй асуудал гэлтэй. Амьдралын хугацаанд л өөрийгөө би хэмээн бодитоор мэдрэгч хүн ингэхэд жинхэнэ би мөн үү гэх мөнхийн асуулт хөндөгдөж байгаа юм. “Өглөө нар хөөрлөө. Тэнгэр цэлмэг, дулаахан сайхан өдөр таарлаа. Болд эхнэрийнхээ булшийг эргэхээр арц, хүж, атга будаа, хайрцаг чүдэнз цуглаж аваад тэр жил төрсөн өдрөөр нь эхнэр нь бэлэглэснээс хойш хадгалж явдаг алчуурандаа боож аваад гэрээсээ гарлаа. Оршуулгын энгэрт нам гүм, амьтан хүн, унаа тэрэгний бараагүй, зам зуурт хэдэн тагтаа л нисэж бууж үзэгдэх аж. Гэнэт, хаанаас ч юм, их ойрхноос Болдыг дуудах сонсогдлоо. Болд зогсоод, хэн, хаана харагдана? гэж ийш тийш нүд гүйлгэлээ.

Ойр хавьд нь ганц ч хүн харагдсангүйд ихэд гайхлаа. “Хэн нэгэн дуудчихаад, надаар даажигнаж нэгтээ нуугдчихлаа!” гэж бодоод нэлээд удаан хүлээж, ийш тийш дахин дахин нүд гүйлгээд хаа ч, юу ч эс харагдсанд “Хий юм” сонсож дээ! гэж санаад цааш алхав. Хоёр, гурав алхтал, өөртэй нь яг зэрэгцээд алхаж яваа хөлийн чимээ тод сонстов. Болдын хамаг биеийн үс өрвөсхийж жигтэй айн зогтуслаа. - Битгий ай гэх үг дуулдлаа.

Болдын өвдөг өөрийн эрхгүй чичрэн, гар нь хүйт даан салгалж, - Чи хаана байна аа, хэн бэ? гэж эрүү нь давжин арай ядан асуув. - Хажууд чинь! Надад нэр байхгүй! Чи өөрөө нэг нэр өг! Чиний өгөх нэр, -Миний нэр! (Д.Урианхайн гар бичмэлийн эрхтэй эхээс авав, 2023: 15) “Хий юм”, Болд хоёр ингэж “танилцдаг”. Хүн өчүүхэн, аймхай, зөвхөн өөрийн мэддэг туршлагаа л үнэн, жинхэнэ, бодит гэж боддог ажээ.

Гэтэл түүний туршлага, мэдлэгээс гадуур “оршигч нэгэн” байдаг байна. “Хүн байдаггүй гэж бодож явдаг юмтайгаа таарвал хэцүү болдог” хэмээн хамба лам Д.Нацагдорж ярьсан (МонГал Товчоон IX – Өв тээгч нэвтрүүлэг) юм. Гэхдээ эл өгүүллэгт Болдтой таарсан нь ийм “гүйдэл” арай биш бололтой. Үүнд л цаад сэтгэлгээний бичвэрийн онцлог байдаг. Тиймээс энэ “Хий юм”-ыг зуучлагч сүнс гэж нэрлэе. Яагаад гэвэл тэр “юм” Болдыг талийгаач эхнэртэй нь уулзуулж өгсөн юм. Энэ гэхдээ амьдрал дээр байж болох зүйл үү? Бид зүүдэлдэг, тэр байтугай сэрүүн зүүд мэт сонин мэдрэмж төрдөг. Хүн амьдралдаа нэг бус удаа ийм туршлага туулсан байдаг. Өдөр, шөнө хоёр байдаг шиг эрс тэс хоёр сүлэлдэн, ил ба далд хоёр зэрэгцэн байх нь хүний хувьд аймшиг бөгөөд гайхамшиг юм. Тиймээс Болдын талийгаач эхнэр нөхрийнхөө хувьд харамсал гунигт дурсамж байх бол, сүнс болсон эхнэрийн хувьд өнө мөнхрөл болсон мэт. Үүнд л толины гайхамшиг оршино. Өнөөдөр технологи хөгжсөөр метаверс¹ ертөнцийн загварыг дүрсэлж эхэлсэн.

Өгүүллэг цааш өрнөхдөө Болдын талийгч эхнэр “- Аа, “Тэр” үү? “Адаг чуулганы орд”-ны “Зуун найм” дугаар одны гэрлийн ойлт манай нарнаас Дэлхийд тусдаг гэрлийн ойлттой есөн сая жилд нэг удаа огтлолцдог цэгээс бид хоёрыг уулзуулж байна. Ганц энд л бид хоёр уулзаж чадна. Дахиад хоёулаа есөн сая жилийн дараа уулзана! гэв.” (Д.Урианхайн гар бичмэлийн эрхтэй эхээс авав, 2023: 15). Орон зай, цаг хугацаа, амьдрал, үхэл, хайр, хагацал ... гэж байхгүй, тийм хүлээс биднийг энд тогтоож байгаа. Амь, амьдралыг зохиогч ийм байхаар шийджээ.

Гайхамшигт толь..., толины тухай аймшигт түүх яриа их байдаг. Шөнө орой толинд бүү хар сүнс нь зайлдаг, үхсэн хүний сүнс толиндоо хоргоддог, нас барсан хүний толь бүрсийж өнгөө алддаг ... гэх мэт олон туршлага бидэнд байна. Энэ амьдрал нь ирээдүйн амьдралын толин тусгал байж болно, бүх юм сүлэлдэн нууцлагджээ. Урам зоригт, авьяас билэгт, онгод төгс уран бүтээлчид хүн төрөлхтөнд энэ үнэнийг тунхагласаар иржээ. Хүний нас хязгаартайн адил хүний бодол оюун, чадвар чансаа хязгаартай ажээ, тэр нь ч зөв байх. Гэлээ гээд хүн сэтгэхээ зогсохгүй, нар сар, дөрвөн цаг ээлжилсээр цагт юмс өөрийн жамаар өрнөсөөр л, байх юмгүй, бас байхгүй юмгүй л хорвоо юм.

Өрнө дахины уран зохиолд энэ мэт хүний оршихуйн бүхий л ай савыг хамран туурвих уламжлал хүчтэй тогтсон байдаг бөгөөд үүнийг сэрж, бүтээлчээр туршин хөгжүүлж буй анхны монгол зохиолчийн нэг бол зохиолч Д.Урианхай юм.

¹ Метаверс гэдэг нь виртуал ертөнцөд суурилсан нийгмийн харилцааны сүлжээ юм. Виртуал ертөнц гэж компьютероор бүтээсэн дуураймал орчныг тодорхойлдог.

Дүгнэлт

Зохиолч Д.Урианхай хүүрнэл зохиол бичиж эхэлсэн эхний он жилүүддээ реалист чиглэлээр бичиж байсан. Гэхдээ реалист бус хандлага, туршилтууд байсан нь зохиол бүтээлээс нь харагддаг.

Зохиолч Д.Урианхай нь хүүрнэл зохиолоо туурвихдаа өөрөө хөндлөнгөөс харж зохиолын баатарт өөрийнхөө үзлийг шингээн амьдралыг үзэх үзлээ илэрхийлж байна. Д.Урианхайн зохиол бүтээлд сэтгэлгээний бодрол нээлт, философийн ойлголт, ухагдахуун элбэг бөгөөд философийн олон ай савд хамаарах шашин хийгээд нийгмийн ухааны нийлбэр, нэгтгэл бүхий синкретик хандлага, ухаарал эсвэл эрэл хайлт бүхий бичвэрийн онцлогтой юм.

Зохиолч Д.Урианхайн хүүрнэл зохиолд түүний гүн ухааных нь үзэл бодол, хандлага тод тусгалаа олсон байна. Зохиолч өөрийн уран бүтээлийн зорилгоо тодорхойлохдоо “би марксизмд нэг сүрхий засвар хийхийг хүсэж байна” гэсэнчлэн тэр үнэхээр марксизмын монгол онцлогтой хөгжүүлэлтийн санааг загварчилсан байна. Үүнд “Гудманд уулзсан бүсгүй” өгүүллэг жишээ болох юм. Энэ санаа цааш боловсорч “Эх үр-философи захидал” болжээ.

Ном зүй

- Байгалсайхан С.** 1999. *Ерээд оны хүүрнэл зохиолын хөгжлийн төлөв*. Монголын орчин үеийн уран зохиолын түүхэн сургамж. Улаанбаатар.
- Байгалсайхан С.** 2010. *XX зууны монгол өгүүллэгийн туурвилзүй*. Улаанбаатар. “Сэлэнгэ пресс” ХХК. 178х.
- Байгалсайхан С.** 2014. *XX зуун, тууж судлал*. Улаанбаатар. “Соёмбо принтинг” ХХК.
- Баттөр Ш.** 2010. *Монголын модернист уран зохиол*. Улаанбаатар. “Сэлэнгэпресс” ХХК.
- Баттөр Ш.** 2017. *1990-ээд он: Монголын уран зохиолын шинэ хандлага*. Улаанбаатар. “Жиком Пресс” ХХК.
- Гаадамба Ш.** 1989. *Утга зохиолын онолын үндэс*. Улаанбаатар. УХГ.
- Галбаатар Д.** 2002. *Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь*. Токио.
- Галбаяр Г.** 2004. *XX зууны Монголын уран зохиолын хөгжлийн үе шатууд*. Улаанбаатар.
- Дулам С., Хасбаатар Ц.** 1980. *Утга зохиолын онолын үүд*. Улаанбаатар. УХГ.
- Урианхай Д.** 2018. *Тавдугаар боть /Тууж-I/*. Улаанбаатар. “Тоонотпринт” ХХК.
- Урианхай Д.** 2018. *Зургаадугаар боть /Тууж-II/*. Улаанбаатар. “Тоонотпринт” ХХК.
- Урианхай Д.** 2018. *Долоодугаар боть /Өгүүллэг/*. Улаанбаатар. “Тоонотпринт” ХХК.
- Урианхай Д.** 2018. *Наймдугаар боть /Эсээ-Бодрол/*. Улаанбаатар. “Тоонотпринт” ХХК.
- Урианхай Д.** 2018. *Есдүгээр боть /Роман-I/*. Улаанбаатар. “Тоонотпринт” ХХК.
- Урианхай Д.** 2018. *Аравдугаар боть /Роман-II/*. Улаанбаатар. “Тоонотпринт” ХХК.
- Чулуунбат С.** 2005. *Д.Урианхайн намтар уран уран бүтээл*. Улаанбаатар.